

Сумын Засаг даргын 2022 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 4/30 дугаар захирамжийн хавсралт



## БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН ОНЫ ШИЛДЭГ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

Сумын эдийн засаг, нийгмийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан, тухайн салбар болон байгууллага, хамт олноо хошуучлан манлайлж, онцгой амжилт гаргасан ажилтан, албан хаагч, иргэдийг шалгаруулж, шагнаж урамшуулах, улмаар улс, аймгийн шилдгүүдийг бэлтгэхэд энэхүү журмыг мөрдөнө.

### Хоёр.Оны шилдэг шалгаруулах төрөл, шалгуур үзүүлэлт

#### 2.1 Оны шилдгүүдийг шалгаруулах төрөл

- 2.1.1 Шилдэг төрийн түшээ
- 2.1.2 Боловсролын салбарын шилдэг ажилтан
- 2.1.3 Эрүүл мэндийн салбарын шилдэг ажилтан
- 2.1.4 Соёл, урлаг, спортын салбарын шилдэг ажилтан
- 2.1.5 Шилдэг Соёлын биет бус өв тээгч
- 2.1.6 Шилдэг сурагч
- 2.1.7 Төрийн үйлчилгээний салбарын шилдэг ажилтан
- 2.1.8 Хувийн хэвшлийн салбарын шилдэг ажилтан
- 2.1.9 Шилдэг аж ахуйн нэгж, байгууллага

#### 2.2 Оны шилдгүүд шалгаруулах шалгуур үзүүлэлт

| №  | Төрөл               | Шалгуур үзүүлэлт                                                                                                      |
|----|---------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. | Шилдэг төрийн түшээ | 1.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт А-ээс доошгүй үнэлгээтэй байх                                                    |
|    |                     | 2.Шинэлэг бүтээлч ажил хийсэн байх                                                                                    |
|    |                     | 3.Төрийн үйлчилгээг шударга, шуурхай, чанартай хүргэж тэдний зүгээс гомдол гаргаагүй байх (байгууллагын тодорхойлолт) |
|    |                     | 4.Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахиж, баг, хамт олноо манлайлсан байх (хэрэглэгчийн үнэлгээг ирүүлэх)   |
|    |                     | 5.Бодлогын чанартай асуудал дэвшүүлж шийдвэрлүүлсэн байх ба ажлын зохих арга                                          |

|    |                                     |                                                                                                                                                                   |
|----|-------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|    |                                     | туршлага хуримтлуулж бусдын хүртээл болгосон байх                                                                                                                 |
|    |                                     | 6.Өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хууль тогтоомж, төр засгийн бодлого шийдвэрийг иргэдэд хүргэж хэвшсэн, сургалт сурталчилгааны ажлыг тогтмолжуулсан байх.      |
|    |                                     | 7.Мэдлэг, чадвараа дээшлүүлсэн байх (сертификат, гэрчилгээг хавсаргах)                                                                                            |
|    |                                     | 8.Сахилгын болон захиргааны шийтгэл хүлээгээгүй, иргэний үүргээ зохих ёсоор биелүүлсэн, сумын харьяаллын иргэн байх /холбогдох тодорхойлолт лавлагааг хавсаргах/  |
| 2. | Боловсорлын салбарын шилдэг ажилтан | 1.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт А үнэлгээтэй байх                                                                                                            |
|    |                                     | 2.Багш, шавийн амжилтаараа улс, аймгийн уралдаан тэмцээнд 1-5 байр эзэлсэн байх                                                                                   |
|    |                                     | 3.Багшийн ёс зүйн, нэр хүндийг өндөрт байлган манлайлагч байх (хэрэглэгчийн үнэлгээг ирүүлэх)                                                                     |
|    |                                     | 4.Ур чадвар, хэлэлцүүлэг, илтгэлийн уралдаанд оролцож бүтээл нь аймаг бүсийн хэмжээнд шалгарсан байх                                                              |
|    |                                     | 5.Багш (сурагч)-ийн ахиц амжилтын судалгаа, сурлагын чанарыг хөндлөнгийн үнэлгээгээр 70(С)-ээс дээш оноо авсан байх                                               |
|    |                                     | 6.Багш, сурагчийн бүтээлийн цахим сантай болж бүс, аймаг, улсад түгээн дэлгэрүүлсэн байх                                                                          |
|    |                                     | 7.Сургалтын таатай орчин бүрдүүлэх талаар санаачилгатай ажиллаж шинэлэг ажил нэвтрүүлсэн байх                                                                     |
|    |                                     | 8.Сурагч, эцэг, эх, багшийн гурвалсан холбоо бэхжүүлж хамтын ажиллагааг бий болгосон байна.                                                                       |
|    |                                     | 9.Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх ажилд санаачилгатай оролцсон байх                                                                                                |
|    |                                     | 10.Сахилгын болон захиргааны шийтгэл хүлээгээгүй, иргэний үүргээ зохих ёсоор биелүүлсэн, сумын харьяаллын иргэн байх (холбогдох тодорхойлолт лавлагааг хавсаргах) |
|    |                                     | 1.Тухайн жилийн ажлын үнэлгээ 90-ээс доошгүй байх                                                                                                                 |
|    |                                     | 2.Бие дааж мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн, багаар ажиллах чадвартай байх                                                                                            |
|    |                                     | 3.Харьцаа хандлага соёлтой үйлчилгээ үзүүлж хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаагаар хангалттай сайн үнэлгээ авсан байх                                         |

|    |                                              |                                                                                                                                                                  |
|----|----------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 3. | Эрүүл мэндийн салбарын шилдэг ажилтан        | 4.Дээд газрын шалгалтанд хангалттай үнэлгээ авсан байх                                                                                                           |
|    |                                              | 5.Мэргэжлийн чиглэлээр судалгаа хийсэн, гарын авлага зөвлөмж гаргасан байх                                                                                       |
|    |                                              | 6.Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой мэргэжлийн зөрчил гаргаагүй байх                                                                                      |
|    |                                              | 7.Хариуцаж буй хөтөлбөр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулж үр дүнд хүрсэн                                                                     |
|    |                                              | 8.Үйлчлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх ажилд санаачлагатай оролцсон байх                                                                                           |
|    |                                              | 9.Сахилгын болон захиргааны шийтгэл хүлээгээгүй, иргэний үүргээ зохих ёсоор биелүүлсэн байх                                                                      |
| 4. | Соёл, урлаг, спортын салбарын шилдэг ажилтан | 1.Аймаг, сум, бүсийн урлагийн наадамд амжилттай оролцож 1-3 байр эзэлсэн байх                                                                                    |
|    |                                              | 2.Бэлтгэсэн шавь эсвэл өөрөө урлагийн тоглолт хийсэн байх                                                                                                        |
|    |                                              | 3.Ардын уламжлалт урлагийн хөгжүүлэх өсвөр залуу үеийхэнд зааж сургаж өвлүүлсэн байх (шавьтай болсон байх)                                                       |
|    |                                              | 4.Орон нутгаас зохиож буй урлагийн ажилд оролцож идэвх зүтгэл гаргасан байх                                                                                      |
|    |                                              | 5.Хөдөлмөрчдөд уран сайхнаар үйлчилсэн байх                                                                                                                      |
|    | Соёл урлаг                                   | 6.Соёлын биет болон биет бус өвийг уламжлуулж, иргэд олон нийтэд суртачилан таниулж, сургалт зохион байгуулж, шавь бэлтгэн уламжлуулсан байх                     |
|    |                                              | 7.Сахилгын болон захиргааны шийтгэл хүлээгээгүй, иргэний үүргээ зохих ёсоор биелүүлсэн, сумын харьяаллын иргэн байх (холбогдох тодорхойлолт лавлагааг хавсаргах) |
|    | Спорт                                        | 1.Аймаг, сум, бүсийн спортын наадамд амжилттай оролцож 1-3 байр эзэлсэн байх                                                                                     |
|    |                                              | 2.Спортын тухайн төрлөөр тасралтгүй хичээллэж хойч үедээ өвлүүлсэн байх (шавьтай байх)                                                                           |
|    |                                              | 3.Уралдаан тэмцээнийг зохион байгуулж, санаачилсан байх                                                                                                          |
|    |                                              | 4.Тамирчны ёс зүйг эрхэмлэсэн байх                                                                                                                               |
|    |                                              | 5.Сахилгын болон захиргааны шийтгэл хүлээгээгүй, иргэний үүргээ зохих ёсоор биелүүлсэн, сумын харьяаллын иргэн байх (холбогдох тодорхойлолт лавлагааг хавсаргах) |

|    |                                                    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
|----|----------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 5. | Шилдэг сурагч                                      | <p>1.Сурлагын амжилтаараа 7,8-р шатлалын үнэлгээнээс дээш байх (сурлагын ахиц, амжилтын үнэлгээг харгалзана)</p> <p>2.Улс, аймгийн олимпиад, уралдаан, тэмцээнд байр эзэлсэн байх.</p> <p>3.Илтгэл, реферат, эссэ, тайлан тоглолт, үзүүлэн гэх мэт өөрийн бүтээл, амжилттай байх</p> <p>4.Анги хамт олны дунд нэр хүндтэй хүмүүжлээрээ үлгэр жишээч, сахилга баттай манлайлагч байх</p> <p>5.Эко орчин бүрдүүлэх ажилд санаачлан оролцдог байх</p> <p>6.Сурагчдын өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг дэмжин оролцдог байх</p> <p>7.Бие даан сурах арга барил эзэмшсэн байх</p>                                                   |
| 6. | төрийн үйлчилгээний салбарын шилдэг туслах ажилтан | <p>1.Тухайн жилийн ажлын гүйцэтгэлийг 85-аас дээш хувиар үнэлүүлсэн байх</p> <p>2.Байгууллагын үйлчилгээний соёл, өнгө үзэмж, эрүүл ахуй, цэвэр байдлыг бүрдүүлэхэд шинэлэг санал санаачлага гаргаж ажилласан байх</p> <p>3.Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөж, харилцаа хандлагаар манлайлж эерэг орчин бүрдүүлж ажилласан байх (хэрэглэгийн үнэлгээг ирүүлэх)</p> <p>4.Байгууллагын болон нийтийн арга хэмжээнд идэвх санаачлагатай оролцдог байх</p> <p>5.Сахилгын болон захиргааны шийтгэлгүй, иргэний үүргээ зохих ёсоор биелүүлсэн, сумын харьяалалтай иргэн байх (холбогдох тодорхойлолт лавлагааг хавсаргах)</p> |
| 7. | Хувийн хэвшлийн салбарын шилдэг ажилтан            | <p>1.Хариуцсан ажил үүргээ хангалттай биелүүлсэн байх</p> <p>2.Удирдлага хамт олны 100 хувийн санал авсан байх</p> <p>3.Ажил, үйлчилгээндээ, шинэлэг санал санаачлага гаргаж ажилласан байх</p> <p>4.Харьцаа хандлагаараа манлайлан эерэг орчин бүрдүүлж ажилласан байх</p> <p>5.Цаг үеийн нийтийг хамарсан ажилд идэвх санаачлагатай оролцдог байх</p> <p>6.Сахилгын болон захиргааны шийтгэл хүлээгээгүй, иргэний үүргээ зохих ёсоор биелүүлсэн, сумын харьяалалтай иргэн байх (холбогдох тодорхойлолт лавлагааг хавсаргах)</p>                                                                                                       |

|    |                                  |                                                                                             |
|----|----------------------------------|---------------------------------------------------------------------------------------------|
| 8. | Шилдэг аж ахуйн нэгж байгууллага | 1.Ажил үйлчилгээ нь стандартын шаардлага хангасан байх                                      |
|    |                                  | 2.Нийгмийн хариуцлагын хүрээнд бүтээлч, шинэлэг ажлуудыг санаачлан хийсэн байх              |
|    |                                  | 3.Цаг үеийн нийтийг хамарсан ажилд идэвх санаачлагатай оролцдог байх                        |
|    |                                  | 4.Байнгын ажлын байрыг тогтвортой хадгалсан байх                                            |
|    |                                  | 5.Шинэ, брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлсэн, хөгжүүлсэн байх                         |
|    |                                  | 6.Гадаад дотоод орчины тохижилт стандартын түвшинд хүрсэн байх                              |
|    |                                  | 7.Мэдээ, тайлан орлогоо үнэн зөв бөглөсөн байх                                              |
|    |                                  | 8.Сахилгын болон захиргааны шийтгэл хүлээгээгүй, иргэний үүргээ зохих ёсоор биелүүлсэн байх |
|    |                                  | 9.Хуулиар хүлээсэн иргэний болон аж ахуй нэгжийн үүргийг зохих ёсоор биелүүлсэн байх        |

## 2.3 Төрөл тус бүрт хамаарах байгууллага, албан хаагч

2.3.1 Төрийн шилдэг түшээ төрөлд ИТХ, ЗДТГ, Сумын хэсгийн байцаагч, Сумдын ойн ангийн албан хаагчид болон харьяа төрийн байгууллагуудын удирдах албан хаагчид хамаарна.

2.3.2 Боловсролын салбарын шилдэг ажилтан төрөлд Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгийн нийт багш, эрхлэгч, сургалтын менежер, нягтлан бодогчид хамаарна.

2.3.3 Эрүүл мэндийн салбарын шилдэг ажилтан төрөлд эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сувилагч хамаарна.

2.3.4 Соёл, урлаг, спортын салбарын шилдэг ажилтан төрөлд Соёлын төвийн багш, номын санч, техникч болон ардын уран сайханч иргэд, биеийн тамирын багш, нийт тамирчид хамаарна.

2.3.5 Төрийн үйлчилгээний салбарын шилдэг ажилтан төрөлд төрийн байгууллагын туслах үйлчилгээний ажилтан /нярав, туслах багш, асрагч, үйлчлэгч, жолооч, слесарь, цахилгаанчин, галч, жижүүр гэх мэт/-ууд хамаарна.

2.3.6 Хувийн хэвшлийн салбарын шилдэг ажилтанд төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийт ажилтнууд хамаарна.

2.3.7 Шилдэг сурагч төрөлд ерөнхий боловсролын сургуулийн нийт сурагчид хамаарна.

2.3.8 Шилдэг аж ахуйн нэгж, байгууллага төрөлд сумын нийт аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад хамаарна.

## **Гурав.Бүрдүүлэх материал**

3.1 Тухайн иргэний анкет (хавсралт хүснэгтийн дагуу), ажил байдлын тодорхойлолтын хамт олны хурлын тэмдэглэлийн хамт албан бичгээр ирүүлнэ.

3.2 Зарим шаардлагатай зүйлийг зургаар баримтжуулсан байж болно.

3.3 Бүтээлийн жагсаалт

## **Дөрөв.Шалгаруулах журам**

4.1 Шалгаруулалт 2 үе шаттай байна.

4.2 Нэгдүгээр шатны шалгаруулалтыг баг, байгууллага, аж ахуйн нэгж хамт олны дунд явуулж журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангасан 1 хүний тодорхойлолтыг энэхүү журмын 6.2-т зааснаар тухайн жилийн 12 дугаар сарын 20-ны дотор ЗДТГ-т тус тус ирүүлнэ.

4.3 Хоёрдугаар шатны шалгаруулалтыг материал хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, төрөл тус бүрт шалгуур үзүүлэлт хангасан 1 хүнийг шалгаруулна.

4.4 Шаардлагатай гэж үзвэл ИТХ-ын зөвлөл, ЗДЗ-ийн өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлнэ.

## **Тав.Шагнал олгох хугацаа**

5.1 Оны шилдгээр шалгарсан иргэдэд "Өргөмжлөл", дурсгалын зүйл олгож, шагналын зардлыг Засаг даргын нөөц хөрөнгө болон тухайн байгууллагын төсвөөс шийдвэрлэнэ.

5.2 Шагнал гардуулах хугацаа

5.2.1 Шинэ жилийн баяраар:

1.Шилдэг төрийн түшээ

2.Боловсролын салбарын шилдэг ажилтан

3.Эрүүл мэндийн салбарын шилдэг ажилтан

4.Соёл, урлаг, спортын салбарын шилдэг ажилтан

5.Шилдэг Соёлын биет бус өв тээгч

6.Шилдэг сурагч

7.Төрийн үйлчилгээний салбарын шилдэг ажилтан

8.Хувийн хэвшлийн салбарын үйлчилгээний шилдэг ажилтан

9. Шилдэг аж ахуйн нэгж, байгууллага

БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН ОНЫ ШИЛДЭГТ  
ТОДОРХОЙЛОХООР МЭДҮҮЛСЭН ХҮНИЙ ТОВЧ АНКЕТ

1.Овог:

2.Нэр:

3.Төрсөн он:

4.Хүйс:

5.Төрсөн аймаг, сум, хот:

6.Одоогийн харьяалал:

7.Нийгмийн байдал:

8.Регистр №:

9.Боловсрол:

10.Ажилладаг салбар:

11.Мэргэжил:

12.Урьд болон одоо ажиллаж байгаа газар:

| № | Ажлын газар | Хугацаа | Эрхэлсэн ажил |
|---|-------------|---------|---------------|
| 1 |             |         |               |
| 2 |             |         |               |
| 3 |             |         |               |

13.Урьд нь шагнагдаж байсан шагналууд: /он цагийн дарааллаар/

| № |  |  |
|---|--|--|
|   |  |  |

14.Шагнуулах үндэслэл:

15.Ямар шагналаар шагнуулах хамт олны санал:

16.Хамт олны саналын хувь:

ДАРГА...../...../  
Гарын үсэг                      Гарын үсгийн тайлал

3x4 цээж  
зураг